


Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр -18
Шөнө -27



УЛС ТӨР

Н.УЧРАЛ: АРБИТРЫН ХУУЛИЙГ
ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА
ЗҮЙ ЁСООР БАЙСАН

II нүүрт

СПОРТ

“РЕАЛ МАДРИД” 40 ТОГЛОЛТ
ЯЛАГДААГҮЙ ЦУВРАЛЫНХАА АРААС
ХОЁР ДАРААЛЖ ХОЖИГДЛОО

VI нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

МАН-ЫНХАН МАШ ТОМ УЛС ТӨРИЙН СОЁЛ ГАРГАЛАА



Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын
Ерөнхийлөгчийг сонгох ээлжит

сонгууль энэ оны зургадугаар сард болно. Энэ сонгуулиар Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч тодрох учиртай.

Тэгвэл Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө “хэрүүлийн алим” болсон нэг сэдэв гарч ирсэн нь Ерөнхийлөгчийн

сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах зарим заалт.

Үргэлжлэл нь III нүүрт

BEST OF MONGOLIA-2016



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“Монголын мэдээ” сонин “Best of Mongolia”-аар шалгарлаа

Ж.ОТГОН

Монголын Хэвлэл Мэдээллийн Бизнес Эрхлэгчдийн Холбоо, WWW.BESTOFMONGOLIA.MN тав дахь жилдээ “Best of Mongolia” салбар салбарын оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгжийг хэрэглэгч олон нийтийн санал асуулгаар тодрууллаа. Эдүгээ таван жилийнхээ ойтой золгож буй “Best of Mongolia-2016” өчигдөр ёслол төгөлдөр зохион байгуулагдсан юм. Уг санал асуулгыг Монголын Хэвлэл Мэдээллийн Бизнес Эрхлэгчдийн Холбоо www.bestofmongolia.mn сайттай хамтран зохион байгуулсан бөгөөд санал асуулга 2016 оны арванхоёрдугаар сарын 10-31-ний өдрийг дуустал явагдаж, хамгийн олон санал авсан байгууллага, аж ахуйн нэгжүүд “Best of Mongolia -2016”-ын шилдгээр тодорлоо. Ёслолын үйл ажиллагааг нээж “Best of Mongolia” төслийг санаачлагч, Монголын Хэвлэл Мэдээллийн Бизнес Эрхлэгчдийн Холбооны Ерөнхийлөгч Б.Ганзориг “Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хэдэн арван мянган аж ахуйн нэгжүүд байна.

Үргэлжлэл нь VIII нүүрт

Дугаарын 60 мөр

Монгол хүн л Монгол Улсыг тэжээнэ


Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Уг нь монгол хүнд хийж чадахгүй зүйл үгүй бололтой. Саяхнаас Н.Цэнгэл, С.Гантулга, Г.Чулуунхүү нарын гурван залуу инженер автомашины дугуй, арас ясны төмрөөс бусдыг чанарын өндөр төвшинд үйлдвэрлэн зах зээлд захиалгаар нийлүүлээд эхэлчихэж. Энэ гурван залууд ажлын байр, багаж зэвсэг гээд байх зүйл үгүй шахам. Өөрөөр хэлбэл, залуу хүний хийж бүтээх гэсэн хүсэл тэмүүлэлдээ хөтлөгдөн өдөр

нь тус тусын ажлаа хийцгээд үдэш оройдоо орон сууцны хонгилдоо цугларч, шөнөжин үйлдвэрлэл явуулдаг гэсэн үг. Бүтэн жил үргэлжилсэн туршилт нь амжилттай болж, тэдний хийсэн супер чанарын тухайд япон чанарыг давжээ. Гэхдээ тэдэнд аж ахуйн нэгж байгуулах сонирхол үгүй бололтой. Ганц эд биш жижиг үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдэд компани байгуулах нь хөл дээрээ босох арга зам бус харин ч эсрэгээр дарамт болдог байна.

Үргэлжлэл нь III нүүрт

ДОТОР НҮҮРТ



СИ ЗИНЬПИН
ЦӨМИЙН
ЗЭВСГИЙГ
ХАЛАХЫГ
УРИАЛЛАА

4

ҮЗЭЛ БОДОЛ

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

Өнгөрсөн долоо хоногт “Мөнхжин Од” хэмээх компанийн үйлдвэрлэсэн архинд таван хүн хордож нас барсан хэрэг гарч, нийслэлийн хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх шийдвэрийг гаргасан. Мөн тэтгэвэрийн зээлийн хүү буурсан талаар ХНХЯ-аас мэдээлэл хийв. Үүнээс гадна Давос хотноо Дэлхийн эдийн засгийн 47 дахь удаагийн чуулга уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож буй зэрэг олон үйл явдал өрнөлөө. Энэ хүрээнд хэн хэн, ямар байр суурь илэрхийлснийг “Хэн юу хэлэв” булангаараа онцлон хүргэж байна.

Ж.Батбаясгалан: Энэ сарын 20–ны өдрийг дуустал архи худалдан борлуулахыг зогсоосон

/Нийслэлийн Засаг даргын орлогч, нийслэлийн Онцгой комиссын орлогч дарга /

Таван хүн хордож, амиа алдсан хэрэгтэй холбогдуулан нийслэлийн Онцгой Комиссын Ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэгт нийслэлийн Засаг даргын орлогч, нийслэлийн Онцгой комиссын орлогч дарга Ж.Батбаясгалан ахлаж, Улаанбаатар хотын

Цагдаагийн газрын дарга Ж.Эрдэнэболд, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга Л.Эрдэнэчулуун, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар, Нийслэлийн онцгой байдлын дарга Н.Уламбаяр нарын гишүүд багтсан юм. Тэд дээрх таван иргэн ямар зүйлд хордсон талаар мэдээлэл хийсэн. Энэ үеэр Нийслэлийн Засаг даргын орлогч, нийслэлийн Онцгой комиссын орлогч дарга Ж.Батбаясгалан “Нийслэлийн Засаг даргын зөвлөл өргөтгөсөн зөвлөл хуралдаж шийдвэр гаргасан.

Үргэлжлэл нь III нүүрт

19 дэх жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины
I улирлын
нэмэлт захиалга
үргэлжилж
байна

Улиралд 44 дугаар

Захиалгын үнэ 19800



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025



ХААН банк					Худалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2485.00	2502.00	ФУНТ	3002.00	3105.00	АМ.ДОЛЛАР	2486.00	2502.00	ФУНТ	3016.00	3094.00
ЕВРО	2614.00	2685.00	РУБЛЬ	40.20	43.70	ЕВРО	2615.00	2683.00	РУБЛЬ	40.55	43.94
ИЕН	21.49	21.85	ЮАНЬ	361.00	365.90	ИЕН	21.45	22.02	ЮАНЬ	361.00	366.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

ҮЗЭЛ БОДОЛ

ҮЗЭЛ БОДОЛ

МАН-ЫНХАН
МАШ ТОМ УЛС ТӨРИЙН СОЁЛ ГАРГАЛАА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Энэ хуулийн төслийг 2016 оны арванхоёрдугаар сард МАН, АН-ын нэр бүхий гишүүд өргөн барьж, УИХ-аар хэлэлцүүлсэн. Мэдээж хэлэлцүүлгийн явцад янз бүрийн санал гарсан, хэлэлцсэн, ярилцсан. Түүний хажуугаар зарим намын төлөөлөл энэ хуулийг эсэргүүцэж, байр сууриа илэрхийлж байв. Тухайлбал, МАХН-ыг төлөөлж УИХ-д сууж байгаа О.Баасанхүү гишүүн хоёр, гурван хэвлэлийн хурал хийж, МАН ганцаараа л Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээ өрсөлдүүлэх боломжтой хуулийг батлах гээд байна хэмээн давшилсан. Мөн Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-ын дарга Н.Энхбаярыг өрсөлдөх бүхий л боломжийг хааж байгаа талаар ч нэлээд ярьсан. Мань хүн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн талаар ярихдаа хэтэрхий нам руугаа хазайлгаад, улс төр хийгээд байсан болохоос биш учир дутагдал байгаа талаар ярьсан нь үнэн. Дээрээс нь АН-ын зарим гишүүд ч асуудлыг ярьж, байр сууриа илэрхийлж байсан. Дээрээс нь иргэд, сонгогчид ч бас үзэл бодлоо илэрхийлж, цахим ертөнцөөр сэтгэгдлээ илэрхийлсэн. Энэ бүхний эцэст МАН улс төрийн том соёл гаргаж, өчигдөр Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслөө эргүүлэн татаж, хууль санаачлагчид нь буцаалаа. Энэ талаар УИХ-ын гишүүн Я.Содбаатар өчигдөр Төрийн ордонд сэтгүүлчдэд мэдээллээ. УИХ дахь МАН-ын бүлэг өнгөрсөн лхагва гарагт хуралдаж, нийм шийдвэрт хүрсэн юм байна. Тэгэхдээ гурван үндэслэлээр хуулийн төслийг буцааж татаж байгаа аж. Энэ талаар Я.Содбаатар гишүүн “Нэгдүгээрт, өмнөх парламентын үед УИХ, орон нутаг, Ерөнхийлөгчийн сонгуулийг нэг хуулиар буюу Сонгуулийн тухай хуулиар зохицуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү нэгдсэн хуулиас Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг дангаар салган хэлэлцэх явцад өмнөх хуулийн зохицуулалтаа хэрхэн хүчингүй болгох асуудал нарийвчлан тусгагдаагүй учраас процедурын хувьд хүндрэлтэй байгаа юм. Энэ хууль гарснаар өнөөдөр хүчин төгөлдөр байгаа Сонгуулийн хуулийн 189 заалтыг хүчингүй болгох шаардлага гарсан. Энэ бол хуулийн техник, хууль батлах процедур талаасаа хүндрэл

дагуулж байгаа юм. Хоёрдугаарт, МАН улс орны нийтлэг эрх ашгийг дээдлэн, аливаа асуудалд үндэсний зөвшилцлийг эрхэмлэж ажилладаг улс төрийн хүчин. Ялангуяа бид парламентын төвшинд асуудлыг шийдэхдээ 65 суудалтай гэж дулдуйдахаасаа илүү парламентын зөвшилцөл, ойлголцлыг баримтлах сонирхолтой байгаа. Гэтэл хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй 149 санал гаргасан нь энэ хуулиар парламентын төвшинд нэгдсэн ойлголцолд хүрээгүй байгааг илтгэж байна. Тийм учраас энэ хуулийг цаашид хэлэлцүүлэх боломжгүй байна. Гуравдугаарт, цаг хугацааны хүчин зүйл нөлөөлж байгаа. УИХ-ын нэр бүхий гишүүдийн өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөлд тусгасан хуулийн хугацаануудтай зөрчилдөн цаашид хуулийн хугацааг өөрчлөх шаардлага бий болоод байна. Улс төрийн зарим намууд завсарлага авсан. Хэлэлцүүлгийн явц сунжирсан гээд нэлээд олон асуудлаас болоод хуулийн хугацаа хойшилж байгаа учраас өмнөх Сонгуулийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулах боломжтой гэж үзэж байна. Ийм гурван үндэслэлээр хууль санаачлагчид нь буцааж байгаа юм” хэмээлээ.

...Гэвч тэд тэгсэнгүй, аливаа асуудалд үндэсний зөвшилцлийг харж, бодолцож шийдвэр гаргаж чаддаг гэдгээ харууллаа. Тиймээс Ерөнхийлөгчийн сонгууль хуучин хуулийнхаа дагуу л явах болж байх шиг байна...

Мэдээж хуулийг хэлэлцэж, батлахад хүндрэлтэй зүйл байгаа нь тодорхой. Тэр болгоныг бодолцож, улс төрийн соёл гаргаж, зөв шударга ажиллах үүднээс МАН хуулийн төслөө буцааж татсан байх. Түүнээс биш ганц нэг хүн улс төр хийлээ гээд, жижиг намын дарга нарын

ярианаас айгаад ч юм уу хуулийн төсөл буцааж татна гэж юу байх вэ. Харин тэдний ярьсан, хэлсэн дундаас зөвийг нь сонсч, тунгааж, болох, болохгүй аль аль талаас нь харж үзээд л буцааж татлаа. Түүнээс биш үхэр шиг муйхарлан дайрсан бол хэдэн заалт хүчингүй болгож цөхөх зүйлгүй, уг нь. Нэг өдрийн хуралдаанаар л уншаад, гар өргөөд, хүчингүй болгоод л явчихаж болох байв. 65 суудалтай намд ямар санал дутахын зовлон байх биш. Хүч түрэх шиг амархан юмалга. Гэвч тэд тэгсэнгүй, аливаа асуудалд үндэсний зөвшилцлийг харж, бодолцож шийдвэр гаргаж чаддаг гэдгээ харууллаа. Тиймээс Ерөнхийлөгчийн сонгууль хуучин хуулийнхаа дагуу л явах болж байх шиг байна. Үндсэндээ УИХ-д суудалтай намын төлөөлөл Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөөд л явна. Сонгууль бодлогоороо болно, нэг хүн Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Харин цаашид бид УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулийг нэг хуулиар зохион байгуулдаг байдлыг өөрчлөх хэрэгтэй байх. Элдэв хэрүүлгүй, аажуу уужуухан, дараагийн сонгуулиас өмнө зохицуулахад л хангалттай. Энэ удаагийн “хэрүүлийн алим” бол ингээд нэг тийшээ шийдэгдлээ. Улс төр хийгээд байсан хүмүүс одоо өөрсдөө жаахан улс төрийн соёлд суралц.

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Олон тооны иргэд хордсон байдалтайгаар амь нас нь эрсдсэн учраас шүүх шинжилгээний эцсийн дүн гарах хүртэл Улаанбаатарын хотын иргэдийн амь нас эрүүл мэндийг хамгаалах үүднээс өнөөдрийн 18:00 цагаас нэгдүгээр сарын 20-ны өдрийг дуустал архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулахыг зогсоосныг мэдэгдэж байна” хэмээсэн бол Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга Ж.Эрдэнэболд “Мэргэшлийн байгууллагууны үүднээс хэлэхэд хохирогч нарт шүүхийн шинжилгээ хийсэн байгаа. Тэдний дөрөв нь шингэн зүйлээс хордсон гэсэн дүгнэлт гарсан байгаа. Яг ямар бодисоос хордсон болох нь эд эсийн нарийвчилсан шинжилгээгээр гарна. Үүнд хугацаа шаардлагатай. Энэ хэрэгтэй холбоотойгоор хэргийг газраас шингэн зүйлийг олж илрүүлэх, хураах арга хэмжээг авсан байгаа. Архи, согтууруулах ундааг худалдаалахыг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байгаа нь иргэдийн аюулгүй байдлыг хангах, эрсдлээс хамгаалах үүднээс хийж байгаа ажил гэдгийг хэлэх байна” гэсэн юм. Ямартай ч энэ хүрээнд, НМХГ-аас техникийн болон хүнсний спиртийн хяналтыг дэлгүүрүүдэд хийнэ. Мөн стандарт нийцсэн үйл ажиллагаа явуулж буй эсэхэд шалгалт хийхээр болсон бол ЭМГ-аас ойр орчимд нь архи согтууруулах ундаа уусан, хүнсний бүтээгдэхүүн хэрэглээд хордлогын шинж тэмдэг илэрсэн бол яаралтай 103 дугаарт хандах хэрэгтэйг сануулсан юм.

Н.Номтойбаяр: 1–6 сарын хугацаатай зээл авч байгаа тэтгэврийн зээлийн хүү 15 хувь болно

/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр тэтгэврийн зээлийн хүү буурсантай холбогдуулан мэдээлэл хийсэн юм. Тэрбээр “Тэтгэврийн зээлийн хүүг 18 хувиас 15 болгож бууруулах шийдвэр өнөөдрөөс /2017.01.18/ хэрэгжиж эхэлсэн. Эхний ээлжинд нийт тэтгэвэр авагчийн 91 хувь нь үйлчлүүлдэг

“Хаан” болон Төрийн банктай гэрээ байгуулж, хүүг бууруулсан. 1-6 сарын хугацаатай зээл авч байгаа тэтгэврийн зээлийн хүү 15 хувь болно. Харин одоо 18 хувийн хүүтэй зээл авчихсан иргэд зээлээ төлж дууссаны дараа шинээр зээл авахдаа 15 хувь руу шилжинэ. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс тэтгэвэр авах иргэн үйлчлүүлэх банкаа өөрөө сонгодог болсон. Өмнө нь зөвхөн “Хаан” болон Төрийн банкаар дамжуулан олгодог байсан иргэд тэтгэврээ хүссэн банкаараа авдаг болсноор үйлчлүүлэгчээ татахын тулд шимтгэл, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, үйлчилгээгээ сайжруулах гэх мэтээр шударга өрсөлдөөний зарчимд шилжих ач холбогдолтой юм. Одоогийн байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгосон 6,000 гаруй хүн өөрсдөө банкаа сонгосон бол урьд тэтгэвэр авагчдын хэдэн хувьд үйлчилж байгааг хууль журамтай нь нийцүүлж, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг тухайн зээлийн эргэлт, зээлийн багцтай нь уялдуулж байршуулж байна. Жишээ нь, Төрийн банк, “Хаан” банкинд 45 тэрбум төгрөг байршуулсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг 15 хувиас доошгүй байдлаар хадгаламж хэлбэрээр арилжааны банкуудад байршуулна гэсэн шийдвэр гаргасан. Тэгэхээр тооцож байгаа 15 хувь, тухайн банктai харилцан тохиролцоод дөрөв болбол 11 хувиар, тав болбол 10 хувиар байршуулах замаар шийднэ. Одоогийн байдлаар хоёр банкинд 45 орчим тэрбум төгрөг байршуулсан байгаа. Хууль зөрчиж байгаа зүйл байхгүй. Зээлийн орлого ч буураагүй. 36 тэрбумаар нэмэгдсэн” хэмээсэн юм.

Ц.Элбэгдорж: Монгол Улс Давосын чуулга уулзалтад хүлээн зөвшөөрөгдсөн түнш болж чадлаа, энэ бол бидний том ололт

/Монгол Улсын Ерөнхийлөгч/

Давос хотноо Дэлхийн эдийн





засгийн 47 дахь удаагийн чуулга уулзалт болж буй. Энэхүү чуулга уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож байгаа бөгөөд энэ сарын 18-нд “Бүс нутгийн эрчим хүчний төслүүд” сэдэвт хэлэлцүүлэг уулзалтад оролцож, үг хэлсэн байна. Тус уулзалтаар “Азийн супер сүлжээ” төсөл, бүс нутгийг хамарсан эрчим хүчний төслийг хэрэгжүүлэхэд гарах боломж, эрсдийн талаар хэлэлцжээ. Мөн энэ үеэр Ерөнхийлөгч Монголынхоо хэвлэл мэдээллийнхэнд ярилцлага өгчээ. Тэрбээр “Монгол бол боломж бага олддог улс гэж хэлж болно.

Сайн боломж олдвол ашиглах хэрэгтэй. Давосын чуулга уулзалт бол хүссэн

алдахгүй ашиглах учиртай. Энэ чуулга уулзалтад Монгол Улс оролцохдоо эхнээсээ барьсан бодлого бол зөв үнэлгээ авах ёстой гэсэн байр суурь. Монголоос ирсэн төлөөлөгчид манай энэ чуулга уулзалтад хувь нэмэртэй орох юм, хуралдаан, хэлэлцүүлэгт оролцож үг хэлдэг, санал дэвшүүлдэг, цаашдын хамтын ажиллагааны чигээ тогтоож чаддаг, түүнийгээ Монголдоо очоод үргэлжлүүлдэг, монголчууд харагдахуйц хэмжээнд оролцож байна гэсэн үнэлгээг эхний жилээсээ авах гэж оролдсон. Өнгөрсөн найман жилд Монгол улс Давосын чуулга уулзалтад хүлээн зөвшөөрөгдсөн түнш болж чадлаа. Энэ бол бидний том ололт” хэмээн онцолжээ.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Үндсэн хуулийн цэцгийн гишүүн, эрх зүйч, улс төр судлаач Д.Солонго

Дугаарын 60 мөр

Монгол хүн л Монгол Улсыг тэжээнэ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургаар аймаг, нийслэл дүүргийн татварын байцаагч нар ААН байгуулж, татвараа төл хэмээн дарамталж эхэлдэг аж. Үнэн хэрэгтээ, эдгээр залуучууд шиг халаасандаа мөнгөгүй, байгаа мөнгөө нийлүүлж байгаад үйлдвэрлэл явуулах түүхий эдээ худалдаж авчихаад сууж байгаа хүмүүст ААН байгуулж, татвар төлөх нь байтугай түрээсээ хэрхэн төлөх тухайд аргай үйлээ барж байгаа нь ч бий. Тиймээс төр, засаг алс ирээдүйтэй, импортын бараа бүтээгдэхүүнийг орлохуйц, эдийн засгийн үр өгөөжтэй үйлдвэрлэл явуулах дүр төрх бүхий иргэдээ дэмжиж, тэднийг төсөлд хамруулах эс бөгөөс ажлын байраар ханган түүхий эдийг нь гаалийн татвараас чөлөөлж өгч яагаад болохгүй гэж. Өндөр хөгжилтэй улс орнуудын хөгжилд хүрсэн түүх ийм л байдаг юм билээ. Ганцхан жишээ дурьдаа. АНУ гоц авьяастай, алс хэт нь улсын нэр нүүрийг гаргахуйц шинэ технологи, шинэ бүтээл туурвигчдаа дэмжин Цахиуртын хөндийг байгуулж өгсөн байх юм. Тэр л хөндийд дэлхий дахинд цахиур хагалсан технологиуд төрөн гарч тэр хэрээр АНУ-ын нэр хүнд өсч байгаа нь ойлгомжтой. Тэр жишгээр Монгол Улс яагаад явж болохгүй гэж. Цахиуртын хөндийг бий болгон, ажлын байр, түүхий эдээр хангаж өгч чаддаггүй юм аа гэхэд татварын дарамтаас чөлөөлж, бодлогоор дэмжээд өгвөл манай залуучууд мөдхөн бөглөрөлт ихтэй үед агаарт хоордог суудлын тэрэг үйлдвэрлэн Монгол Улсын нэрийг дуурсгахад гайхах зүйл алга. Нөгөөтгйгүүр, Монгол Улс байгалийнхаа баалгийг түүхийгээр нь дэлхийн зах зээлээс хэд дахин хямд үнээр экспортолчихоод эргээгээд зах зээлийн үнээр худалдан авч үйлдвэрлэл явуулж байгаа. Үүнийг нотлох олон баримт буй. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт төмрийн хүдрийн асар их нөөц бүхий бүхэл бүтэн уул байсныг санаж байгаа байх. Түүнийг орд газарт Болдтөмөр ерөө гол компани олборлолт явуулан төмрийн хүдрээ түүхийгээр нь тэвш тэвшээр нь Хятад руу экспорлосоор байгаа. Ерөөгийн ард түмний хайрлаж, шүтэж ирсэн Минжийн хангайн салбар уулсын нэг Дулаан ханы ар бэл, Хандгайт уул нунтаг хөх шороо болон хувирсаар эдүгээ уул байсан ор мөргүй болсон төднийгүй эргээд эх нутагтаа өндөр үнэтэй хадаас болж орж ирэх жишээтэй. Мөдхөн шуудайлах хөх шороо ч үгүй болох биз. Чухам тэр цагт өнөөдөр татварын дарамт дор тарчилж буй залуучуудын бүтээл Монгол Улсыг тэжээж мэднэ. Монгол хүн монгол хүнээ тэжээх болохоос биш хямд гээд худалдаж аваад л байх машины салбег чинь эргээд хятад хүнийг Хятад улсыг хоолтой хонуулдаг гэдгийг санахад гэмгүй л болов уу.

ДЭЛХИЙ

СИ ЗИНЬПИН ЦӨМИЙН ЗЭВСГИЙГ ХАЛАХЫГ УРИАЛЛАА

Б.ДАВААХҮҮ

“Эргэх холбоотой, хариуцлагатай манлайлал” ерөнхий сэдвийн дор болж байгаа 47 дахь удаагийн чуулга уулзалт Швейцарийн Давос хотод энэ сарын 17-ны өдөр эхэлсэн. Анх төр засаг бодоод бизнесийнхний яриа хэлэлцээ хийх талбар болгон 1971 онд үүсгэн байгуулж байсан тус эдийн засгийн чуулганы өнгөрсөн 46 жилийн хугацаанд хэлэлцсэн сэдвүүд нь улс төрийн бус, харин санхүү эдийн засгийн хямрал, үнийн уналт, эрчим хүчний эх үүсвэрүүд, худалдааны саад тотгорууд гэх мэт олон улсын харилцаанд дахь эдийн засгийн асуудлууд зонхилж иржээ. Харин энэ жил чөлөөт худалдааг үл дэмжихээ илэрхийлдэг Дональд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон, Их Британи

...Си Зиньпин илтгэлдээ өөрийн зах зээлд гадаадын компаниудын нэвтрэх боломжийг улам сайжруулахаа амлан, Хятад улс юанийг зохиомлоор үнэгүйдүүлж, валютын дайн хийх санаагүй гэдгээ хэлжээ. Мөн худалдааны дайнд хоёр тал хоёул хохирогч болох аюултай гэжээ...

Европын Холбооны эгнээнээс гарах болсон, Франц, Германд удахгүй бүх нийтийн сонгууль болох гэж байгаа зэрэгтэй холбоотойгоор хэлэлцэх сэдвүүд нь улам бүр өргөжиж байна. Тэгвэл чуулганы үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпин тавьсан илтгэл олон улсын анхаарлыг ихээр татлаа. Тэрбээр илтгэлийнхээ үеэр цөмийн зэвсгийг халж, эдүгээ хадгалагдаж буй зэвсгүүдийг ч устгахыг дэлхий нийтэд хандан уриалав. Си “Цөмийн зэвсэггүй дэлхийг байгуулахыг төлөө цөмийн зэвсгийг бүхэлд нь хориглож, тодорхой хугацаанд устгах ёстой” гэж хэлсэн байна. Мөн хүчирхэг улс гүрнүүдийн эрх тэгш харилцаанд үндэслэсэн олон улсын засаглалын тогтолцоог бий болгохыг санал болгож, “Бид нэг улс, аливаа олон улсын дүрмээс татгалзах ёстой” гэдгийг уриалжээ. Мөн дээр нь “Улс орнууд нэг нэгийнхээ үндсэн эрх ашгийг хүндэтгэх ёстой. Том гүрэн өөрийн ашиг сонирхлоо бусад улс оронд тулгаж болохгүй. Жижиг улс гүрэнтэй эрх тэгш орших хэрэгтэй” хэмээнэс байна. Швейцарын Давос хотод дөрвөн өдрийн турш үргэлжлэх чуулганд оролцож

буй Си Зиньпин энэ сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан Давосын ерөнхий хуралдаанд анх удаагаа оролцож илтгэл тавьсан. Тэрбээр энэ үеэр өнгөрсөн сарын АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Д.Трамп ялалт байгуулсантай холбоотойгоор АНУ-ын дэлхий дахинд гүйцэтгэх үүрэгт санаа зовниж буйгаа илэрхийлээд амжсан юм. Хэдийгээр Си дарга Д.Трампын нэрийг дурьдаагүй боловч, АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн үзүүлж байгаа бодлого, үйлдэлд хариу өгөх зорилготой нь илэрхий байлаа. Өнгөрсөн жилийн турш өрнөсөн сонгуулийн сурталчилгааны үеэр Трамп нь Хятадыг “валютын луйварчин” хэмээн цоллож, Хятадын импортын бараанд 45 хувийн гаалийн татвар ногдуулахаа амлаж, Америкийн эдийн засгийн доройтолд Хятадыг буруутгаж байв. Харин Си Зиньпин илтгэлдээ өөрийн зах зээлд гадаадын компаниудын нэвтрэх боломжийг улам сайжруулахаа амлан, Хятад улс юанийг зохиомлоор үнэгүйдүүлж, валютын дайн хийх санаагүй гэдгээ хэлжээ. Мөн худалдааны дайнд хоёр тал хоёул хохирогч болох аюултай гэжээ. Глобалчлалаас зугтах гэсэн ямар ч оролдлого бүтэлтэй болохгүйг тэр мөн онцолсон байна. Тэгвэл зарим шинжээчид Давосын чуулганд тавьсан Си Зиньпиний илтгэл өнөөдөр тангаргаа өргөх Д.Трампын тэргүүлэх АНУ-аас дэлхий нийтийг тэргүүлэх үүргийг булаах зорилготой байсан гэж дүгнэж байлаа.

Хятадын ачааны галт тэрэг Их Британид хүрчээ

Хятадаас Их Британи хүрэх анхны шууд чиглэлийн галт тэрэгний цуваа лхагва гарагт Лондонд ирлээ. Орчин үеийн торгоны замыг хөгжүүлэх Бээжингийн төлөвлөгөөний нэг хэсэг болж буй ихэнхдээ хувцас, гэр ахуйн бараа ачсан уг галт тэрэг зүүн Хятадын Зэжянь мужийн Ивү хотоос Казахстан, Орос, Беларусь, Польш, Баруун Европоор дайран 18 хоног аялсны эцэст Лондон хотын Баркин буудалд хүрсэн байна. Францаас Британи хүрэхдээ Ла Маншийн хоолой доогуурх хонгилоор нэвтэрч 12000 км урт аяллаа өндөрлөжээ. Галт тэрэгний цуваа нэгдүгээр сарын 1-нд аж үйлдвэрийн хот болох Ивүгээс 24 чингэлэг бараатай гарсан юм. Гэхдээ хуучин ЗХУ-ын нутгаар дайрахдаа өргөн царигт тохируулан анх Хятадаас гарсан зүтгүүрээ сольсон гэнэ. Далайн тээврээр үүнээс их бараа зөөх боломжтой боловч шинэ галт тэрэг нь далайгаар тээвэрлэснээс хурдан, агаараар тээвэрлэснээс хямд дундын сонголтыг бизнес эрхлэгчдэд гаргаж өгч байгаа аж. Хятадын төмөр зам Ази-Европыг холбох 10 гаруй чиглэлийг бий болгоод байгаа бөгөөд Лондонгийн энэ аялал 15 дахь нь болж байгаа юм. Гэвч одоохондоо энэ аялал нь эдийн засгийн хувьд төдийлөн ач холбогдолгүй байна. Учир нь далайгаар тээвэрлэхэд нэг удаадаа 10000-20000 чингэлэг тээвэрлэдэг. Мөн буцаад Британиас Хятад руу тээвэрлэх ачаа одоохондоо байхгүй байгаа. Гэхдээ Британи, Франц, Герман зэрэг худалдааны томоохон түншүүдтэйгээ шууд газраар холбогдох нь Бээжингийн хувьд улс төрийн чухал ач холбогдолтой гэнэ.

№11

ЯПОНД ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭ ХЭРХЭН ТӨЛДӨГ ВЭ

Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний түгээмэл асуулт хариултын буланг Японы олон улсын хамтын ажиллагааны талаархи байгууллага /ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны

чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Уншигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Маморү хариулж байна.



ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭ ХЭРХЭН ТӨЛДӨГ ВЭ?

-Японд тэтгэврийн даатгалын шимтгэлээ орон даяар үйл ажиллагаа явуулж буй бүх банк, Хөдөө аж ахуйн хоршоо, загасны аж ахуйн хоршоо, зээлийн эвлэл, зээлийн сангаас гадна томоохон дэлгүүр, интернэтийг ашиглан төлөх боломжтой байдаг. Санхүүгийн байгууллага, мини мартаар дамжуулан шимтгэл төлөх тохиолдолд Японы тэтгэврийн байгууллагын тусгай төлбөрийн

хуудсыг ашиглан төлөх боломжтой. Мөн тухайн шимтгэл төлөгч сар бүр өөрийн үйлчлүүлдэг банкны данснаас автоматаар суутгуулах маягаар төлж болдог. Банкны данснаас автоматаар төлөх тохиолдолд шимтгэлийг хямдруулах систем ч байдаг. Ийм данс нээлгэх, автоматаар шимтгэл төлөх үйлчилгээг ашиглахад ямар нэг хураамж авдаггүй.

ОХУ, Туркийн арми хамтран “Лалын улс”-д цохилт өгөв

Сирийн хойд нутаг дахь “Лалын улс” цэрэгжсэн бүлэглэлийн байрлалд Орос болон Туркийн арми анх удаагаа хамтран агаараас цохилт өгчээ. Оросын Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны газрын дарга Сергей Рудской лхагва гарагт Москва хотод сэтгүүлчидтэй уулзсан байна. Тэрбээр хэлэхдээ “Оросын байлдааны есөн нисэх онгоц, Туркийн найман сөнөөгч онгоц

террористуудын гол түшиц газруудын нэг болох Аль-Баба хотод агаараас цохилт өгөх ажиллагаанд оролцсон” гэв. АНУ болон Туркийн хувьд Сирийн сөрөг хүчнийхнийг дэмждэг бол ОХУ Сирийн Ерөнхийлөгч Башар Аль Асадын засаг захиргааг дэмждэг юм. Өнгөрсөн сард Турк болон Оросын зуучилснаар Сирид гал зогсоох хэлэлцээр байгуулсан билээ. “Лалын улс”-ыг хамтын

хүчин чармайлтаар дарахыг АНУ-ын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Доналд Трамп ч Москвад битүүхэн уриалж, агаараас цохилт өгөх ажиллагааны ач холбогдлыг онцлож байна гэж ажиглагчид үзэж байна. Өнөөдөр тангараг өргөх Д.Трамп ОХУ-тай харилцаагаа бэхжүүлэх сонирхолтой байгаагаа урьд нь нэг бус удаа илэрхийлж байсан юм.

Сургуулийн автобус, ачааны машинтай мөргөлдлөө

Энэтхэгийн хойд этгээдэд бага, дунд ангийн 50 сурагч тээвэрлэж явсан сургуулийн автобус том оврын ачааны машинтай мөргөлдсөний улмаас 15 хүн нас баржээ. Ослын шалтгаан одоогоор тодорхойгүй байгаа ч, албаныхан манантай үзэгдэх орчин хязгаарлагдмал үед жолооч жолооны хүрдээ андуурч буруу тийш нь дарсантай холбоотойгоор осол гарсан гэж үзэн, шалгалтын ажлыг үргэлжлүүлж байгаа юм байна. Осол Уттар Прадеш

мужид өчигдөр өглөө гарчээ. Сургуулийн автобусны эсрэг урсгалаар элс ачсан ачааны машин явж байсан бөгөөд хоёр тээврийн хэрэгсэл огцом урдаасаа мөргөлдсөн гэнэ. Энэ удаагийн ослын улмаас автобус ихээхэн гэмтэж, ачааны машин ч замын хажуу руу унажээ. Цагдаагийн газраас мэдээлснээр, ослоор автобусны жолооч, бага ангийн сурагчид гээд нийтдээ 15 хүн амь үрэгдсэн байна. Харин бусад хүүхдүүдэд эмнэлгийн тусламж үзүүлэхээр

орон нутгийн эмнэлэгт хүргэжээ. Гэхдээ хүнд гэмтсэн хүүхдүүд олон байгаа учир нас барагсдын тоо цаашид нэмэгдэж магадгүй байна. Одоогоор сурагчдын өвлийн амралт дуусаагүй байгаа ч, хувийн сургуулиуд үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байгаа гэнэ. Улмаар тус сургуульд авдаг хүүхдүүдийг автобус тээвэрлэж явжээ. Осол гарах үед өтгөн манантай, ачааны машин, автобусны аль аль нь хурдтай давхиж байсан аж.

ЗӨВЛӨМЖ

УКТЭ-ийн сувилагч Б.ЦЭЦЭГДЭЛГЭР
Д.ДАШСҮРЭН
Б.МӨНХЦЭЦЭГ

Хүүхдийн чих хамар хоолойг гадны биетээс хамгаалахад юуг онцлон анхаарах вэ?

- Хүүхдийн сэтгэлзүйн түгээмэл онцлог нь ямар ч зүйлийг хэзээд шохоорхож, хуруу гараараа оролдох төдийгүй үмхэх, амтлахыг урьтал болгодог шинжтэй байдгийг хэзээ ч мартаж болохгүй. Энэ тал дээр маш соргог байх хэрэгтэй.
- Хүүхдийг хараанаасаа хөндийрүүлж эзгүй орхих, дураар нь тавихгүй байхыг эрхэмлэхийн хамт бага насны хүүхдэд ам, хамарт орж болох жижиг зүйл өгөхгүй байх нь чухал.
- Хүүхдийг ам, хамраа ухах, элдэв юм үмхэх, чих, хамар, хоолойгоо оролдох, маажих мэтийн муу зуршил сургахгүй байх талаар бүр багаас нь анхаарч зөв хэвшил олговол

зохино.

- Хүүхдийг зөв хооллуулж сургахаас гадна тэдэнд самар, үрт жимсний зүйл өгөхдөө хосыг нь арилгаж шалгаж өгөх, хүүхдийг хоол идэж, чихэр хүлхэх зэрэг амандаа юмтай байгаа үед ярихгүй, инээлгэхгүй байхыг аль болохоор хичээх нь зүйтэй.
- Хүүхдийг хагарч муудсан хуванцар, резин тоглоом, ам, хамарт орж болох хялбар жижиг эрэг шурга, жижиг мөнгө, бөглөө, шүр, шигтгээ, товч мэт зүйлээр тоглуулахгүй байх шаардлагатай.
- Гэр ахуйн хэрэгцээнд байнга хэрэглэдэг боловч хүүхдийн ам, хамар, хоолойг амархан гэмтээх, гүлэх үйлчилгээтэй иод, марганц, пууны хүчил болон элдэв эмийн зүйлийг хүүхдэд тэр бүр хүрэхгүй бэхэлгээ, түгжээ сайтай саванд хадгалж, хянуур нямбай хэрэглэж байвал зохино.
- Хүүхдэд эм өгөхөд хүрвэл өгөх бүрийдээ уг эмийн нэр, хэмжээ, өнгө, зүсийг маш сайн анхаарч шалгаж өгдөг байвал зохино.

СПОРТ

ОЛОН УЛСЫН ЖУДО БӨХИЙН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ С.НЯМ-ОЧИРТ
АМЖИЛТ ХҮСЛЭЭ

VII нүүрт

“ЮВЕНТУС” ПЬЯНИЧААР САНЧЕСЫГ
СОЛИХЫГ ХҮСЧ БАЙНА

VI нүүрт



МЭДЭЭЛЭЛ

Туялзуур сэлэмний өсвөр, залуучуудын аваргууд тодорлоо

“Улаанбаатар 2017” туялзуур сэлэмний өсвөр үе, залуучуудын УАШТ дөрөв дэх удаагаа зохион байгуулагдлаа. Тэмцээнд дөрвөн клубийн 69 тамирчин оролцов. Энэхүү тэмцээнд “Уурхайчин” клуб багийн дүнгээр хоёр дахь жилдээ дараалан түрүүлээ. “Хангарьд” клубын тамирчин Б.Хаш-Эрдэнэ давхар цохилт хийж, өсвөр үе, залуучуудын ангилалд түрүүлсэн бол У.Маргад-Эрдэнэ (Уурхайчин) мөн хоёр мөнгөн медаль хүртлээ. Харин Ө.Хишигдэлгэр (Уурхайчин) мөн өсвөрийн ангилалд түрүүлж, залуучуудын ангилалд хүрэл медаль авав. Тэгвэл 17 хүртэлх насны өсвөрийн ангилалд Т.Тулуй (Хангарьд), Г.Сумъяабадлан (Уурхайчин) нарын 13 настай хүүхдүүд медаль хүртэж шинэ үе төрөн гарч ирж буйг харууллаа. Залуучуудын ангилалд Б.Амарзаяа (Уурхайчин) өнгөрсөн жилийн аваргаа хамгаалж түрүүллээ. Тэмцээний хаалтын ёслолд Японы Имабэцу хотын дарга Ёшихару Абэ, Спортын газрын дарга Ёшиаке Оба нар оролцсон юм. Харин тэмцээнд түрүүлсэн хүүхдүүд Японы Аомори мужийн Имабэцу хотод хамтарсан бэлтгэлд хамрагдах эрх авлаа.

АМЖИЛТЫН ЭЗЭН

КОНОР МАКГРЕГОР:

Цохиж
чадахгүй
боолтаоо л
тулаалдана



Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Холимог тулааны спортын Хаан Конор Макгрегор 25 сая ам.долларын төлөө Флойд Мейвезертэй тулна. UFC буюу Ultimate Fighting Challenge холбооны босс Дэн Уайт холимог тулааны дэлхийн аварга Конор Макгрегор, мэргэжлийн боксын дэлхийн аварга асан Флойд Мейведер нарыг хоорондоо үзэлцвэл тус бүрд нь 25 сая ам.долларын шагнал

өгөхөд бэлэн гэдгээ мэдэгдсэн. Гэхдээ ялсан ч, ялагдсан ч шагнал авах юм. Флойд Мейвезер ирэх тавдугаар сарын сүүлчээр 40 насны босго алхах бөгөөд мэргэжлийн бокст өөрийн үл мөрөө тод томруун үлдээсэн домогт аваргын сүүлийн тулаан энэ байж магадгүй гэх таамаг бий. Нийт 49 тулаан хийхдээ ялагдах нь байтугай тэнцэж ч үзээгүй түүнийг бүх цаг үеийн хамгийн агуу боксчдын жагсаалтад оруулах нь гарцаагүй.

Гэтэл холимог тулааны дэлхийн аварга Конор Макгрегор түүнийг халз тулаанд дуудсан нь дэлхий нийтийг шуугиулж орхисон. Хоёр өөр төрлөөр хичээллэдэг, тэс өөр арга барилтай, тус тусын холбоондоо үнэмлэхүй аварга гэгдсэн тулаанчид өөр хоорондоо үзэлцсэн түүх спортын ертөнцөд үгүй. Тиймээс ч олон нийтийн дунд энэхүү тулаан ихээхэн хүлээлт үүсгэд байгаа юм. Энэ утгаараа бид өнөөдрийн дугаартаа

Конор Макгрегорыг сонгон товчхон ярилцлагыг нь орчуулан уншигчиддаа сонирхуулахаар бэлдлээ. Гэхдээ тулааны талаар бус, Конор Макгрегор гэх хэн болох, зорилго, амьдралын хэв маягийнхаа талаар дэлгэсэн сонирхолтой ярилцлагыг сонголоо. Дашрамд дурьдахад, тэрбээр ирэх тавдугаар сард анхны хүүхдээ өлгийдөн авах билээ.

Төгсгөл нь VII нүүрт

Д.Миндаишвилийн тэмцээнээс М.Лхагвагэрэл хүрэл медаль хүртжээ

ОХУ-ын Красноярск хотод Д.Миндаишвилийн Бөхийн академийн нэрэмжит чөлөөт бөхийн уламжлалт олон улсын ХҮ удаагийн тэмцээн болж өнгөрлөө. Тус тэмцээнд ОХУ-ын бүрэлдхүүний 15 улс, муж, Беларусь, Казахстан, Монголын нийт 363 бөх өрсөлджээ. ОХУ-ын бөхчүүдээс жин тус бүрт түрүүлсэн бөхчүүдэд И.Ярыгиний нэрэмжит “Алтан Гран-При” тэмцээнд оролцох эрх олгожээ. Манай бөхчүүдээс “Аварга” биеийн тамирын дээд сургуулийн бөх М.Лхагвагэрэл 125 кг-ын жинд хүрэл медаль хүртсэн байна.



ДУУЛГАХ СОНИН

М.ЗОРИГТ: ЭНЭ ЦАГИЙН МОНГОЛЧУУДЫН АХУЙ АМЬДРАЛЫГ ТҮҮХИЙН ХУУДАСНАА МӨНХӨЛНӨ

–“Бидний цөөхөн монголчууд” төсөл хэрэгжүүлэх санааг хэрхэн олж байв. Яагаад энэ төслийг хэрэгжүүлэх болсон юм бэ?

–Та бүхэн санаж байгаа бол би Өмнөд Солонгос улсыг хөндлөн гулд тойрон унадаг дугуйгаар аялсан. Тэр аяллын үеэр би нэг зүйлийг бодсон. Өмнөд Солонгос улсын газар нутаг Хөвсгөл аймгийн газар нутгаас томгүй юм билээ. Гэтэл Хөвсгөл аймгийн газар нутагтай дүйцэхүйц газарт 11 сая гаруй хүн амьдарч байна. Эндээс бидний монголчууд үнэхээр цөөхөн юм байна гэдгийг мэдэрсэн. Бид гуравхан саяулаа. Тиймээс залуу үедээ нутаг орныхоо түүх, соёл, өв уламжлалыг хадгалан үлдээе гэж бодож энэхүү төслийг санаачилсан. Бид Монгол орноо нэг сум суурин үлдээлгүйгээр ХХI дүгээр зууны үеийн монголчуудын ахуй амьдрал, онгон дагшин байгаль хоорондох шүтэлцээ, уламжлалт ёс, зан заншил,

...“Бидний цөөхөн монголчууд” төсөл амжилттай хэрэгжсэнээр ХХI дүгээр зууны үеийн монголчуудын тухай сан хөмрөгтэй болохын сацуу улс орноороо бахархдаг, нутаг усаа хайрладаг, эв нэгдлийг эрхэмлэдэг Монгол Улсын иргэний мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах юм...

биет болон биет бус соёлын өв, угсаатан ястны тус бүрийн онцлог өнгө төрхийг орчин үеийн техник технологийг ашиглан баримтжуулж, мэргэжлийн өндөр төвшинд цогц архив бий болгож хойч

үедээ үлдээх л энэ төслийн гол зорилго. Энд л манай төслийн гол зорилго оршиж байгаа юм. –Монгол орныг бүтэн тойрно гэхээр нэлээд хугацаа орно шүү дээ. Аяллаа хэрхэн төлөвлөсөн бэ. Төслийн үр дүнд бүтээлүүд гарна гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

–“Бидний цөөхөн монголчууд” төсөл амжилттай хэрэгжсэнээр ХХI дүгээр зууны үеийн монголчуудын тухай сан хөмрөгтэй болохын сацуу улс орноороо бахархдаг, нутаг усаа хайрладаг, эв нэгдлийг эрхэмлэдэг Монгол Улсын иргэний мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Манай төслийн баг 12 хүний бүрэлдхүүнтэй. Бид гурван автомашинтайгаар 21 аймаг, 400 гаруй сум суурин бүрчлэн очно. Ингэхдээ нийт 245 мянган км замыг гурван жилийн хугацаанд туулна. Мэдээж бид аялахын зэрэгцээ ХХI дүгээр зууны монголчуудын

ахуй амьдралыг баримтжуулж хойч үедээ үлдээх зорилготой учраас тодорхой хэмжээний бүтээл хийнэ. Тухайлбал, бүрэн хэмжээний кино, 10 баримтат кино, 20 ном товхимол, аян замын тэмдэглэл зэрэг бүтээлийг хийхээр төлөвлөсөн. Мөн МҮОНТВ-тэй хамтран 400 гаруй цуврал нэвтрүүлгийг хүргэх зэргээс бүрдсэн дуу авианы цогц архивыг үүсгэж, хойч үедээ үлдээнэ. Ер нь төслийн гол ач холбогдол, үр дүн нь зөвхөн Монгол гэлтгүй дэлхийд гайхагдсан соёлын үнэт өв болно гэдэгт бид итгэлтэй байна.

–Налайх хотоос энэхүү төслөө эхлүүлсэн нь сонирхол татаж байна? –Налайх хот бол нийслэлийн маань наран ургах зүг. Тиймээс наран ургах зүгээс аяллаа эхлүүлбэ гэж бодсон. Мөн би Налайх хотод төрсөн, унаган хүүхэд нь. Миний аав, ээж ажил амьдралын гараагаа энэ хотоос эхлүүлж байсан учраас бэлгэшээж, төрсөн нутгаасаа төслөө эхлүүлж байгаа юм.



Н.БАТЗАЯА

НИХААГАД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Мөнхчулуун санагса санаачлан хэрэгжүүлж буй "Бидний цөөхөн монголчууд" төсөл Налайх хотоос эхэллээ. Төслийн нээлтэд УИХ-ын гишүүн асан М.Зоригт, Налайх дүүргийн ИТХ-ын төлөөлөгч С.Амарсайхан, шатрын ОУХМ н.Энхтуул, төслийн багийнхан болон тус дүүргийн иргэд оролцсон юм. Энэхүү төслийг Нэлко, МҮОНРТ, УБФилм, УБинфо, АЖЭТ зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлж байгаа аж. Төслийн багийнхан Монгол орны бүх аймаг сумдаар аялах бөгөөд очсон газар бүртээ "Шүүдэр дундуур" уран сайхны киног үнэ төлбөргүй гаргах юм байна. Нээлтийн үеэр төслийн санаачлагч, УИХ-ын гишүүн М.Зоригттой цөөн хором ярилцлаа.

СПОРТ

FOOTBALL NEWS

“Ювентус” Пьяничаар Санчесыг солихыг хүсч байна

“Арсенал”-ын хагас хамгаалагч Алексис Санчес багтайгаа гэрээгээ сунгаагүй байгаа учраас жил хагасын дараа чөлөөт агент болох юм. Тиймээс түүнийг “Ювентус” сонирхож байна. Харин “Арсенал” эргүүлээд “Ювентус”-ын хагас хамгаалагч Миралем Пьяничийг

сонирхож байгаа учраас энэ наймаанд Санчесыг оролцуулж, солилцоход бэлэн байгаа ажээ. “Ювентус” Санчесыг авснаар Игуаин, Дибала нартай хослуулж, дэлхийн хэмжээний довтолгооны гурвалыг бий болгохыг зорьж байгаа аж. Яг л “Барселона”-гийн Месси,

Суарез, Неймар, “Реал Мадрид”-ын Бейл, Бензема, Роналдо нарын хэмжээнд хүрэхээр довтолгооны гурвалтай болох төлөвлөгөөтэй байгаа гэнэ. Түүнээс гадна Санчесыг “Манчестер Сити”, “Атлетико Мадрид” багууд ч бас сонирхож байгаа ажээ.



“РЕАЛ МАДРИД”



40 ТОГЛОЛТ ЯЛАГДААГҮЙ ЦУВРАЛЫНХАА АРААС ХОЁР ДАРААЛЖ ХОЖИГДЛОО

Н.ПУНЦАГБОЛД

Испанийн алдарт “Реал Мадрид” клуб бүх тэмцээнд 40 тоглолт ялагдаагүй байж, Испанийн багуудын түүхэнд байгаагүй гайхалтай амжилтыг үзүүлсэн билээ. Тэгвэл тэдний ялалтын цувралыг “Севилья” зогсоож, 2:1-ээр буулгаж авсан. Тэгвэл энэ хожигдлынхоо араас дахиад нэг ялагдлыг “Реал” амслаа. Тодруулбал, өнгөрсөн

лхагва гарагийн шөнө Испанийн цомын тэмцээний j шигшээн эхний тоглолтын хүрээнд талбайдаа “Сельта”-г хүлээж авч, 1:2-оор хожигдлоо. Тоглолтын 64 дэх минутад Яго Аспас “Сельта”-д тэргүүлэл авчирч. Харин Марсело 69 дэх минутад тэнцүүлжээ. Гэвч 70 дахь минутад Кастро хариуг нь барьснаар “Реал” хоёр тоглолт дараалан хожигдож байгаа нь энэ. Гэхдээ цомын тэмцээн бол хараахан дуусчихаагүй байна.

Хариу тоглолт энэ сарын 25-нд “Сельта”-гийн талбайд болно. Энэ тоглолтод “Реал” хожиж, хагас шигшээд үлдэх бүрэн боломжтой. Хамгийн гол нь 40 тоглолтын турш ялагдаагүй явж байгаад гэнэт хоёр тоглолт дараалан “өвдөг шороодсон” нь тэднийг хэвлэлийнхний бай болгоод байгаа юм. Хамгийн сүүлд 2015 оны арваннэгдүгээр сард “Реал” Рафаэль Бенитесийн удирдлага дор хоёр дараалж хожигдож

байсан юм. Тиймдээ ч түүнийг Эзэн хааны баг халж, Зиданыг дасгалжуулагчаар томилсон. Түүнээс хойш “Реал” жинхэнэ утгаараа ялалтын амтанд бялуурч байсан юм. Зидан багийг авснаас хойш 40 тоглолт дараалан ялагдаагүй, түүнийхээ 30 тоглолтод нь хожоод байсан. Мөн энэ хугацаанд ердөө хоёрхон удаа л хожигдоод байсан юм. Тэгвэл энэ тоо дөрөв болж нэмэгдлээ. “Реал

Мадрид”-ын дасгалжуулагч Зидан тоглолтын дараа нэг л “Тэд яаж тоглосонд би гайхахгүй. Аюултай өрсөлдөгч гэдгийг мэдэж байсан. Нэг их сандрах юм алга. Гэхдээ таатай биш байна. Бидэнд ухрах зам байхгүй. Одоо Ла лигийн тоглолт өмнө хүлээж байгаа. Зөв шийдвэр гаргаж, нөхцөл байдлыг засах үүргийг би хариуцна. Тоглолтын эхлэл хүндхэн байлаа. Бид төлөвлөснөөрөө тоглосонгүй.

Тоглолтдоо бүрэн орж ч чадсангүй. Тиймээс дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Хөлбөмбөгчдийн биений бэлтгэл тааруу байгаагаас хожигдлоо гэж хэлж болохгүй. Тактик, хувилбар дээр ажиллах хэрэгтэй. Ялангуяа довтолгоо дээр. Бид “Реал”-ынхан, үргэлжлүүлэн шаргуу ажиллах ёстой. Одоог хүртэл бид амжилттай явсаар ирсэн. Сүүлийн хоёр тоглолт л нэг болж өгсөнгүй” хэмээн ярьжээ.

Өнгөрсөн улиралд “Манчестер Юнайтед” хамгийн их орлого олжээ

Deloitte хэмээх компани 2015-2016 оны улиралд дэлхийн хөлбөмбөгийн клубүүд ямархуу орлоготой ажилласан талаар судалгаа хийжээ. Тус компани тоглолтогтой өдрүүд, телевизийн цацалт, худалдааны орлогыг тооцсон бөгөөд тоглогч худалдсан орлогыг оруулаагүй юм байна. Тэгвэл Английн “Манчестер Юнайтед” клуб өнгөрсөн улиралд 515 сая фунтын орлого олж, рекорд тогтоожээ. Харин “Барселона” клуб 463.8 саяын орлогоор хоёр, “Реал” мөн энэ хэмжээний орлого олж, гуравдугаар байрт бичигджээ. 2014-2015 оны улиралд “Реал” жагсаалтыг тэргүүлж байсан бол энэ удаад хоёр байр уруудсан аж. Оросын багуудаас “Зенит” 147 саяын орлого олсон амжилтаараа 17 дугаар байрт бичигдэж, нэг байр ахисан юм байна. Мөн Английн “Лестер” клуб энэ жагсаалтад орж ирж, 20 дугаар байрт бичигджээ.

Хамгийн их орлого олсон 20 багийн жагсаалт
1 “Манчестер Юнайтед”- 515.3 млн фунтов
2 “Барселона”-463.8
3 “Реал Мадрид”-463.8
4 Байерн Мюнхэн-442.7
5 “Манчестер Сити”-392.6
6 “ПСЖ”-389.6
7 “Арсенал” -350.4
8 “Челси”-334.6
9 Ливерпүүл”-302

10 “Ювентус”-255.1
11 “Боруссия”-212.3
12 “Тоттенхэм”-209.2
13 “Атлетико”-171
14 “Шальке» — 167,9
15 “Рома”-163.2
16 “Милан”-160.6
17 “Зенит”-147
18 “Вест Хэм”-143.8
19 “Интер”-134
20 “Лестер”-128.7

“Марсель” Пайег авахын төлөө зүтгэсээр

Францын “Марсель” Димитри Пайег буцаан авахаар шаргуу хөөцөлдсөөр байна. Хоёр ч удаа санал хүргүүлээд амжилт олоогүй хэдий ч гурав дахь үнийн саналаа тун удахгүй өгөх аж. Эдүгээ 29 настай хагас хамгаалагчийн төлөө

Францын баг эхний ээлжинд 19 саяыг санал болгосон. Гэвч зөвшөөрөөгүй учраас дараа нь 20 сая болгосон. Гэлээ ч “Алхнууд” гол тоглогчоо 30 сая паундаас доогуур үнээр зарахгүй гэсэн байр суурьтай байгаа юм.

Нэгэнт багтаа тоглохыг хүсэхгүй байгаа хөлбөмбөгчийн хүслийг харгалзаж түүнийг хуучин багт бага зэрэг доогуур үнээр зарах магадлал байгааг бас үгүйсгэх аргагүй юм. Зарим хэвлэлүүдийн мэдээлж буйгаар Мануэль

Пеллегринигийн удирдаж буй Хятадын “Хэбэй Форчун” баг Пайед долоо хоногийн 500 мянган паундын цалин амласан ч хөлбөмбөгч өөрөө татгалзаж, зөвхөн “Марсель”-ийг зорихыг хүсч буй гэнэ

“Манчестер Сити” сүүлийн таван жилд тоглогч авахад хамгийн их мөнгө зарцуулжээ

Английн премьер лиг жилээс жилд хүчирхэгжиж, өрсөлдөөнтэй болсоор байгаа билээ. Энэ нь премьер лигийн багууд баян эзэнтэй болж, дэлхийн шилдэг тоглогчдыг үнэ цохиж авч байгаатай холбоотой. Тэгээд ч дэлхийн шилдэг тамирчид Английн багт тоглох сонирхол өндөр байдагтай ч холбоотой юм. Тэгвэл Английн шилдэг зургаан баг сүүлийн таван жилд тоглогч худалдаж авахад хэдэн саяыг үрсэн талаар мэдээлэл гарчээ. Энэ жагсаалтыг “Манчестер Сити” өнгөлж байгаа юм. “Сити” сүүлийн таван жилд тоглогч

худалдаж авахад зориулж 565.65 сая евро зарцуулсан байна. Харин тоглогч зарж 163.1 саяыг олж. Зарлагдсан, олсон мөнгөний зөрүү нь 402.55 сая. Ийм хэмжээний мөнгө зарцуулж байж өнөөдрийн шилдэг багийг бүтээгээд байгаа юм. Энэ жагсаалтын хоёрдугаар байрт “Манчестер Юнайтед”, араас нь “Арсенал” орж, “Челси” дөрөвт жагссан байна. Топ зургаан багаас өнгөрсөн таван жилд хамгийн бага мөнгийг “Тоттенхэм” л зарцуулжээ. Гэхдээ тоглогч худалдаж авсан мөнгөнийхөө хэмжээнд хүрч хөлбөмбөг зарсан

байгаа юм.

Тоглогч худалдаж авахад зарцуулсан дүн
1. Манчестер Сити
Тоглогч худалдан авсан: J565.65m
Тоглогч зарсан: J163.1m
Цэвэр зарцуулалт: +J402.55m
2. Манчестер Юнайтед
Тоглогч худалдан авсан: J528.8m
Тоглогч зарсан: J160.15m
Цэвэр зарцуулалт: +J368.65m
3. Арсенал
Тоглогч худалдан авсан: J298.34m

Тоглогч зарсан: : J92.45m
Цэвэр зарцуулалт: +J205.89m
4. Челси
Тоглогч худалдан авсан: J507.45m
Тоглогч зарсан: : J315.15m
Цэвэр зарцуулалт: +J192.3m
5. Ливерпүүл
Тоглогч худалдан авсан: J365.6m
Тоглогч зарсан: : J244.08m
Цэвэр зарцуулалт: +J121.52m
6. Тоттенхэм
Тоглогч худалдан авсан: J315.45m
Тоглогч зарсан: J314.45m
Цэвэр зарцуулалт: +J1m

Radio Marca: Луис Энрике “Барселона”-тай гэрээгээ шинэчлэх эсэх нь эргэлзээтэй байна

Испанийн алдарт “Барселона” клубын дасгалжуулагч Луис Энрике энэ улирлын төгсгөлд багаа орхиж магадгүй байгаа ажээ. Radio Marca-гийн мэдээлж байгаагаар эдүгээ 46 настай мэргэжилтэн

багийн тоглогчидтойгоо тийм ч сайхан харилцаатай биш байгаа гэнэ. Каталаны зарим тоглогчид, тухайлбал хамгаалагч Жерар Пике багийн дасгалжуулагч Энрикег олон нийт шүүмжилснийг

дэмжиж буйд тэрбээр сэтгэл дундуур байгаа аж. Өмнө нь Энрике “Барселона”-тай дөрөвдүгээр сарын дундуур гэрээгээ шинэчлэх гэж байгаа талаар мэдээ гарсан. Хэрвээ тэрбээр гэрээгээ сунгахгүй бол

Эрнесто Вальверде (Атлетик) болон Роналд Куман (Эвертон) нарын нэг нь Каталаны багт дасгалжуулагчаар ирж магадгүй гэсэн мэдээлэл ч бас байгаа билээ.

СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН

Төгсгөл.
Түрүүч нь V нүүрт

-**Конор, та бага насныхаа тухай бидэнд яриач?**

-Би Дублин хотын Крамлин дүүргийнх. Намайг 17 нас хүртэл манайх тэнд амьдарч байгаад Лукан руу нүүсэн. Гэхдээ Луканд яагаад ч юм тогтож өгөөгүй. 17 нас гэдэг тун эмзэг үе шүү дээ. Бүх найзууд маань Луканд байдаг учраас байнга л хуучин бокс, фитнесс заал руугаа явчихдаг байж билээ.

-**Тэгээд спортын ертөнцөд хөл тавья гэсэн хүсэл хэдийнээс төрж эхлэв?**

-Тамирчин болох хүсэл үргэлж л миний сэтгэлд байсан. Бага байхдаа бусад хөвгүүдийн л адил хөлбөмбөгчин болохыг хүсдэг байлаа. Харин өсч том болохын хэрээр хөлбөмбөг сонирхлыг минь татахаа больж, харин өөрийгөө хэрхэн хамгаалахад суралцах хэрэгтэй болсон. 14, 15-тай л байсан байх. Тэр үеэс л тулааны спортоор хичээллэж, эцэстээ холимог тулааны спорт руу эргэлт буцалтгүй орсон доо.

-**Та спортод дурласан. Тийм ч учраас ажлаасаа хүртэл гарсан?**

-Тийм ээ. Бигагнуурчин байсан. Мөрөөдлөө биелүүлж, холимог тулааны урлагт өөрийгөө бүрэн зориулахаар шийдэж, ажлаасаа хүртэл гарсан. Бусад залуусын адил барилгын талбай дээр өглөө эрт ирж, шөнө дөл хүртэл ажиллахыг хүсээгүй л дээ. Бүтээн байгуулалтын ажил хүнд. Надад тохирох ажил биш байсан.

-**Ажлаасаа гарах таны шийдвэрийг ээж /Маргарет/, аав /Тони/ тань хэрхэн хүлээн авсан бэ?**

-Тэд эхэндээ хүндээр хүлээж авч билээ. Учир нь тэр үед сантехникийн ажил нэлээд эрэлттэй байв. Мэргэжлийн, туршлагатай гагнуурчин бол мөнгө сайн олдог байсан үе. Эцэг, эх маань ч намайг мэргэжлээ зөв сонгосон хэмээн их баяртай байдаг байлаа. Ийм ажлаасаа гарна гэж хэлэхэд тэд тийм ч таатай хандаагүй. Гэхдээ цаг хугацаа өнгөрөхөд тэд намайг юунд бүхнээ зориулж буйг ойлгосон. Намайг шийдвэрээсээ буцахгүй, юунд ч бууж өгөхгүй гэдгийг тэд харсан. Тэгээд л эцсийн эцэст би ялж, тэд намайг бүрэн дүүрэн дэмжих болсон доо.

-**Харин одоо бол таниар бахархдаг байх?**

-Мэдээж, тэгэлгүй яах вэ. Одоо бол тэд миний үнэнч шүтэн бишрэгчид шүү. Бүх л өдрийг онлайнаар UFC, ММА-ын тулаан үзэж өнгөрүүлдэг. Тэднийг хараад би ч баяр хөөртэй болчихдог.

-**Найз бүсгүй Ди тань ч бас өөрийн тань шүтэн бишрэгч байх. Өнөөдөр ч гэсэн та хоёр хамтдаа ирж зураг авалтад орсон. Ер нь анх та хоёр яаж танилцсан юм бэ?**

-Өмнө нь би түүнийг зүс мэддэг байлаа. Харин анх удаа

нэг шөнийн клубт олж хараад, ярилцаж байсан юм. Би түүн дээр түрүүлж очоод, зүгээр л чатлаж болох уу гэж асуусан. Тэр надад сайн бүсгүй шиг санагдсан. Ер нь надад хөөрхөн гэхээсээ илүүтэйгээр сайн бүсгүйчүүд таалагддаг.

-**Хүчирхэг эрийн ард хүчирхэг эмэгтэй байдаг гэх үг бий. Энэ үг та хоёрын харилцааны хувьд хэр үнэний ортой вэ, Конор?**

-100 хувь. Тэмцээний рингэнд гарч эхэлснээс хойш өдөр бүр тэр намайг дэмждэг. Тэр л намайг фитнесс клуб руу жолоодож, миний бүхий л мөрөөдлийг сонсч, бас дэмждэг. Ди миний хувьд амьдралын минь аврагч. Хэрвээ тэр байгаагүй бол би юу ч хийж чадахгүй байх байсан. Түүний төлөө л бол бүхнийг хийнэ.

-**Найз бүсгүйтэйгээ хангалттай их цагийг**


...Нэгэнт л тулааны бизнест хөл тавьсан л бол өөрөө өөрийгөө сурталчлах шаардлагатай болдог. Ярьж, явж байж л хүмүүс чамайг сонирхоно. Хэрэв чамайг хүмүүс сонирхож байвал тулаанд ялах, эсвэл ялагдахыг чинь харах гэж мөнгө төлдөг юм. UFC-ын тулааныг хэр олон хүн сонирхож үзэж байна, төдий чинээгээр их мөнгө халаасална гэсэн үг...

өнгөрүүлж чадахгүй байгаадаа буруутай юм шиг санагдаж байсан үе бий юу?

-Бид ихэнх цагаа хамтдаа өнгөрүүлдэг. Тун дотно харилцаатай. Бүх зүйл сайн. Олон жилийн турш надтай хамт амьдарсан хүн шүү дээ. Мэдээж, заримдаа хэцүү үе тулгарч л байсан. Амьдрал угаасаа хэцүү. Гэхдээ эцсийн эцэст үнэ цэнэтэй байх л хэрэгтэй.

-**Яаж тэр вэ?**

-Гэрбүлийнхээ ирээдүй, Дигийн ирээдүйг баталгаатай болгохын тулд л би тулалддаг. Хэзээ нэг өдөр, Дитэй хамт дэлхийн аль нэг хэсэгт санаа зовних зүйлгүй, наран шарлагын газарт биеэ шарахыг хүсч байна. Үүний төлөө л би явж байна. Хэзээ нэгэн цагт хүүхдүүдтэй болохдоо санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн байхыг хүсч байна.



ЦОХИЖ ЧАДАХГҮЙ
БОЛТЛОО Л ТУЛАЛДАНА

-**Конор, өөрийгөө хэр романтик гэж боддог вэ?**

-Мэдэхгүй. Магадгүй тийм ч романтик биш байх.

-**Яриаг тань сонсоход та бүхий л зүйлсийг найз**

бүсгүйнхээ төлөө хийдэг юм байна. Тийм ч учраас их романтик залуу байх нь гэж бодлоо?

-Өөртөө л романтик. Өөрийн эмэгтэйнхээ төлөө өөрийгөө

зориулж байна.

- Ер нь гэмтэж, бэртэх вий гэж санаа зовдог уу?

-Юу ч тохиолдохгүй болохоор энэ тал дээр санаа зовдоггүй. Цохиж чадахгүй болох хүртлээ л

тулалдана. Тийм болохоор таны асуусан шиг зүйл хэзээ ч миний ой ухаанд орж ирж байгаагүй. Харин өрсөлдөгч маань зүгээр байгаа даа гэж бусад хүмүүст л санаа зовдог.

-**Бие бялдарын сургуулилт амьдралын тань ихэнх хувийг эзэлдэг. Бидэнд биеэ хөгжүүлэх талаар зөвлөгөө өгөөч?**

-Долоо хоногийн даваагаас баасан гараг хүртэл би өдөрт гурван удаа дасгал сургуулилт хийх дуртай. Бямба, нямд ч дасгалаа таслахгүй. Гэхдээ илүү хүйтэн чанарын усанд сэлж, гүйдэг. Өдөр бүр л дасгал хөдөлгөөн хийж байх хэрэгтэй. Тэгж байж л биеийн формоо барина шүү дээ. Үнэндээ, миний хувьд дасгал, сургуулилт хийхгүйгээр нэг өдөр ч байж чаддаггүй.

-**Зарим өглөө сургуулилтаа хийх хэрэгтэй байдаг, гэтэл өөр илүү чухал ямар нэг зүйл хийх хэрэгтэй мэт бодогдох үе байдаг уу?**

-Тийм. Заримдаа өглөө сэрээд, фитнес заал руу явахдаа өөрөө өөртэйгээ тэмцэлдэнэ шүү дээ. Гэхдээ бид тулаан, тэмцээний төлөө амьдардаг улс. Хэрэв би хийхгүй бол өөр хэн нэгэн надаас илүү гарчих учраас тэр. Ингэж байж л хэн нэгэн хүнээс илүү байж чадна.

-**Хэн нэгэн өөрийг тань даган дуурайж, үлгэрлэх талаар бодож байв уу?**

-Үгүй ээ, бодож байгаагүй. Хүмүүс намайг харвал, өөрийнхөө хийж байгаагаа харуулж, түүнээсээ урамшдаг. Тэр л надад гайхалтай. Би залуу байна. Хэн нэгний үлгэр жишээ авах хүн болохыг хүсэхгүй байна.

-**Амжилт гаргахад юу шаардлагатай вэ?**

-Нэгэнт л тулааны бизнест хөл тавьсан л бол өөрөө өөрийгөө сурталчлах шаардлагатай болдог. Ярьж, явж байж л хүмүүс чамайг сонирхоно. Хэрэв чамайг хүмүүс сонирхож байвал тулаанд ялах, эсвэл ялагдахыг чинь харах гэж мөнгө төлдөг юм. UFC-ын тулааныг хэр олон хүн сонирхож үзэж байна, төдий чинээгээр их мөнгө халаасална гэсэн үг.

-**Мухаммад Али Дублиных. Харин дараагийнх нь таныг гэж Райн Тюбриди хэлсэн байж билээ. Энэ талаар таны бодлыг сонирхмоор байна?**

-Мухаммад Али бол домог. Би түүнийг харж, түүн шиг болохыг мөрөөдөж өссөн. Тэр бас их хөгжилтэй, загварлаг эрхэм байж билээ. Райн ингэж хэлсэнд үнэхээр баяртай байна.

-**Таны загварын хэв маяг Крис Юбенкийг санагдуулдаг. Өмнө нь өөр хүн танд ингэж хэлж байсан уу?**

-Та л анх удаа хэлж байна.

-**Эцэст нь, Конор. Чи дэлхийн хаана ч байж болно. Гэхдээ Ирландыг хэзээ ч битгий мартаарай?**

-Хэзээ ч мартахгүй. Би Ирландых. Хаашаа ч явахгүй.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ



Э.Цэндбаатар жингээ өөрчлөхгүй

Боксын 2017 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 10-15-ны өдрүүдэд болсон билээ. Тэгвэл эрэгтэйчүүдийн 56 кг-ын жинд Олимпын наадамд оролцож, шагналт тавдугаар байрт шалгарсан Э.Цэндбаатар жин өгсч, 60 кг-ын жинд оролцсон. Улмаар энэ жингийн шилдэг тамирчин, Олимпын наадмын хүрэл медальт Д.Отгондалайг ялж, түрүүлсэн билээ. Тиймээс бокс сонирхогчид түүнийг цаашид 60 кг-ын жинд өрсөлдөх нь хэмээн бодож байх. Тэгвэл Э.Цэндбаатар 56 кг-ын жиндээ л тэмцээн уралдаанд оролцох аж. Харин сая улсын аваргын өмнө жиндээ орж чадаагүй учраас 60 кг-д өрсөлдсөн юм байна. Түүнээс биш жин өгсч өрсөлдөх бодолгүй байгаа ажээ.

БНХАУ-ын дарга Ши Жиньпин ОУОХ-ын тэргүүн Томас Бах нар уулзлаа. Швейцарын Лозанн хотноо болсон уулзалтын үеэр ирэх 2022 онд болох өвлийн олимпын талаар ярилцжээ. 2008 оны зуны олимпын наадмыг хүлээн авч байсан Бээжин хот 14 жилийн дараа буюу 2022 оны өвлийн олимпыг зохион байгуулах эрх авсан. БНХАУ-ын дарга Ши Жиньпин анх удаа Олон Улсын Олимпын Хороо /ОУОХ/-оор зочлох үеэрээ таван жилийн дараа болох цагаан наадмын талаар ярилцсан байна. ОУОХ-ны ерөнхийлөгч Томас Бах олимпын наадам зохион байгуулсан туршлагатай,



материаллаг бааз хангалттай учраас Бээжин хот 2022 оны өвлийн олимпын сунгаанд ялалт байгуулсан хэмээн

уулзалтын үеэр онцолжээ. Мөн уулзалтын дараагаар Шин Жиньпин гэргий Пэн Лиюан болон бусад албаны хүмүүсийн хамтаар олимпын музейгээр зочилжээ.



"BEST OF MONGOLIA 2016"

“Монголын мэдээ” сонин



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“BEST OF MONGOLIA”-ААР ШАЛГАРЛАА



Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Тэдний үйл ажиллагаа бизнесийн амжилт гэдэг шууд хэрэглэгчээсээ хамаардаг болохоор бидний зүгээс зөвхөн хэрэглэгч, зах зээлээс олон нийтийг түшиглэж анх “Best of Mongolia-2012” олон нийтийн цахим санал асуулгыг зөвхөн онлайн орчинд бүтэн сарын турш эхлүүлж байсан. Одоо ч тэр уламжлал хэвээрээ явж байгаа. “Best of Mongolia” бол шууд хэрэглэгчээс тухайн байгууллагын үйл ажиллагааг үнэлүүлдэгээрээ онцлог юм. Хэдэн хүн сууж шийддэг биш. Хэдэн мянган хэрэглэгч үнэлэлт өгдгөөрөө онцлог юм. Бизнесийнхэн хэрэглэгч бол хаан гэж ярьдаг шүү дээ. Үнэхээр хэрэглэгч хаан юм бол тухайн жилийнхээ бизнесийн байгууллага үйлчилгээг хэрэглэгчийн саналаар шийддэг байх нь зөв болов уу гэж бид анх энэ ажлыг эхлүүлж байсан. Ер нь бол бид төр, хувийн хэвшлийн компаниудын PR-ийг л олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийсэн. Чимээ гаргаад байдаггүй тэгсэн хэрнээ нийгмийн хариуцлагаа дээд зэргээр биелүүлдэг олон хүмүүсийн ар гэр, ахуй амьдралыг шийддэг, улсдаа татвараа төлдөг компаниуд манайд маш их байдаг. Тэдний үйл ажиллагаа бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд ил гаргаж сурталчилсан хэрэг. Тэгэхээр тодорхой хэмжээнд хүмүүст хүрсэн гэж үзэж байгаа. Бид “Best of Mongolia”-г арван жил тасралтгүй хийнэ. Энэ онд таван жилийн ойн нь болж байна” хэмээсэн юм.

Цахим орчинд явагддаг энэхүү санал асуулгаар

хамгийн өндөр санал авсан 66 байгууллага шилдгээр шалгарч, өчигдөр батламжаа гардан авлаа. “Best of Mongolia” бол шууд хэрэглэгчээс тухайн байгууллагын үйл ажиллагааг үнэлүүлдэгээрээ онцлог юм. Өөрөөр хэлбэл, хэн нэгэн эсвэл хэдхэн хүн ширээ тойрч суугаад шилдгүүдийг шалгаруулчихдаггүй. Хэдэн мянган хэрэглэгч үнэлэлт өгдөг гэдэг утгаараа энэхүү “Best of Mongolia” шагнал үнэ цэнэтэй юм. Тэгвэл Монголын мэдээ сонин хувьд ч өнгөрсөн 19 жилийн хугацаанд хамтдаа байсан уншигч олон маань саналаа өгч, манай хамт олныг шилдэг болгосон болохоор бидний хувьд энэ шагнал уншигчдаас маань өгч байгаа том шагнал хэмээн их бэлгэдэн хүлээн авсан юм. Энэ үеэр “Монголын мэдээ” сонины Орлогч эрхлэгч Ч.Чулуунцэцэг “Монгол Улс зах зээлд шилжих үед хэвлэл мэдээллийн байгууллагууд ч мөн дагаад л шилжиж байлаа. Тиймээс бүх хэвлэл мэдээллийн салбарт чөлөөт байдлаар өөрсдийнхөө амь амьдралыг аваад явах ачаа үүрэг ногдсон. Тэгвэл “Монголын мэдээ” сонин энэ хатуу ширүүн он жилүүдэд өөрийнхөө орон зайг бий болгож, зарим тал дээр анхдагч гэдэг байр сууриа хадгалж чадсан. 19 жилийн турш мэдээллийг тэнцвэртэй барьж, тэр хэрээр уншигчдын талархлыг хүлээсэн.

Бидний энэхүү нөр их хөдөлмөр зүтгэлийн үр дүнгийн нэгээхэн илрэл бол энэхүү “Best of Mongolia-2016” шагналын эзэн болсон явдал гэж бид дүгнэж байгаа. Түүнчлэн манайх хэвлэл мэдээллийн зах зээл ялангуяа өдөр тутмын

сонины зах зээлд орон зайгаа эзэлж чадсан шиг ээ цахим ертөнцөд ч мөн орон зайгаа эзэлж, техник технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж чадаж байгаа. Тиймээс манай www.mminfo.mn вэб сайтад өдөр бүхэн зочилж бидний бэлтгэсэн мэдээ, мэдээллийг шимтэн уншиж байдаг уншигч олны маань нэр хүндийн баталгаа болсон шагнал гэж үзэж байна” гэлээ.

Д.Ганбаатар: “Best of Mongolia” булган сүүлтэй сайхан энергитэй шагнал

Энэ жилийн “Best of Mongolia-2016” оны шилдгүүдийг шалгаруулдаг наадмын “Best of best”-ээр энэ удаад Улаанбаатар-Эмпати сургууль, Грандмед эмнэлэг шалгарсан юм. Энэ үеэр “Best of best” шагналыг гардан авсан Улаанбаатар-Эмпати сургуулийн захирал Д.Ганбаатар “Манай сургууль 1994 онд байгуулагдаад 23 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Бидний хувьд “Best of Mongolia” наадмын тайзан дээр дөрөв дэх удаагаа гарч, шагнал хүртэж байгаадаа үнэхээр баяртай байна. Энэ бол манай хамт олны ажлын амжилт, бидний бахархал юм. “Best of Mongolia” шагнал булган сүүлтэй сайхан энергитэй шагнал байдаг юм билээ. Учир нь энэ шагналыг авсаны дараа олон улсын хэмжээний олон шагнал авсан. Одоогийн байдлаар манай хүүхдүүд олон улсын төвшинд 40 гаруй алт, 90 гаруй мөнгө, 60 гаруй хүрэл медаль авсан амжилттай байгаа гээд бодохоор бид ямар амжилттай явааг харж болох байх” гэлээ. Үнэхээр ч

салбар салбарын шилгүүдийг цуглуулж чадсан гэдгийн нэгэн илрэл тод бол дунджаар 500-600 гаруй байгууллага “Best of Mongolia”-ийн цахим хуудсанд бүртгэгдэж өрсөлдөгт байгаа юм. Улмаар нэг сарын турш явахдаа давхардсан тоогоор 1.3 сая цахим хэрэглэгч санал өгдөг байна.

Монгол Улс хэчнээн хүн амтай билээ. Тиймээс энэ хэмжээний санал авч шилдэг болно гэдэг байгууллагуудын хувьд чамлахааргүй амжилт гэдэг нь ойлгомжтой. Энэ оны “Best of Mongolia-2016” Оны шилдэг аймгаар Орхон аймаг шалгарчээ. Энэ үеэр аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү “2016 он манай аймгийн хувьд маш олон амжилт гаргасан жил байлаа. Өнгөрсөн жил Эрдэнэт хот байгуулагдсаны 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ хүрээнд Ерөнхийлөгчийн зарлиг гарч Эрдэнэт хотыг төрийн дээд Сүхбаатарын одон медалаар шаналаа. УИХ болон орон нутгийн сонгуулийн үр дүнгээр шинэ Засаг даргатай болж, шинэ ИТХ байгуулагдаад ажилдаа ороод байна. Аймгийн шинэ удирдлагын баг маань бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө батлаад байна. Эхний төлөвлөсөн ажил хийгдээд үр дүнгээ өгөөд эхэлчихсэн. Тухайлбал, хамгийн сүүлийн ажил гэвэл Засаг дарга маань жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг шинэ жилийн ёслолыг зохион байгуулаагүй. Харин түүнд зарцуулагдах төсвөөр орон гэргүй 10 айлыг орон гэртэй болгож, шинэ жилээ тэмдэглэсэн. Энэ мэт олон ажил хийж байгаа” гэсэн юм. Ингээд энэ жилийн шилдгүүдийг танилцуулъя.

“Best of Mongolia 2016”

1. “Best of best” ЭМПАТИ СУРГУУЛИУД
2. “Best of best” ГРАНД ЭМНЭЛЭГ
3. Оны шилдэг сонин МОНГОЛЫН МЭДЭЭ СОНИН
4. Оны шилдэг аймаг ОРХОН АЙМАГ
5. Оны шилдэг дүүрэг СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ
6. Оны шилдэг ус ундааны бүтээгдэхүүний үйлдвэр ТЭСО КОРПОРАЦИ
7. Оны шилдэг улсын их сургууль МУИС
8. Оны шилдэг дунд сургууль УЛСЫН ТЭРГҮҮНИЙ 84-Р СУРГУУЛЬ
9. Оны шилдэг авто сургууль ДАШИЙДЭЛЭГ АВТО СУРГУУЛЬ
10. Оны шилдэг сургалтын төв МАНЛАЙЛАГЧ СУРГАЛТЫН ТӨВ
11. Оны шилдэг фитнес клуб ИНДИГО БЯЛДАРЖУУЛАХ КЛУБ
12. Оны шилдэг ресторан НОМАДСЫН СҮЛЖЭЭ РЕСТОРАН
13. Оны шилдэг ТББ АМЖИЛТ МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АКАДЕМИ
14. Оны шилдэг электрон барааны дэлгүүр НЕКСТ ЭЛЕКТРОНКС
15. Оны шилдэг авто машин борлуулагч компани МӨНХХАДА ХХК
16. Оны шилдэг продакшн ШИНЭ ҮЕ
17. Оны шилдэг агаарын тээврийн компани МОНГОЛЫН ИРТЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР ХК
18. Оны шилдэг хамтлаг, дуучин ХАРАНГА
19. Оны шилдэг сувилал, амралтын газар БААТАРВАН
20. Оны шилдэг арьс шир, ширэн бүтээгдэхүүн MR
21. Оны шилдэг хургалтийн үйлчилгээ НОЁН ПИЦЦА
22. Оны шилдэг замын компани ЭН ДИ ТИ КЭЙ ХХК
23. Оны шилдэг энтертайнмент, студий В SOUND PRODUCTION
24. Оны шилдэг үл хөдлөх хөрөнгө зуучлалын компани МАСТЕР ПРОПЕРТИС ХХК
25. Оны шилдэг зочид буудал ЧИНГИС ХААН ЗОЧИД БУУДАЛ
26. Оны шилдэг тээвэр зуучлалын компани ТУУШИН
27. Оны шилдэг хувийн хэвшлийн их дээд сургууль МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ
28. Оны шилдэг авто засварын газар MAS
29. Оны шилдэг фото үйлчилгээ VENUS PHOTO STUDE
30. Оны шилдэг кино театр ГЭГЭЭНТЭН ЭНТЕРТАЙНМЕНТ ТӨВ
31. Оны шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр САЙН СҮҮ
32. Оны шилдэг малчинд ээлтэй байгууллага “МАЛЧИН” ГРУПП
33. Оны шилдэг мэдээллийн лавлахын үйлчилгээ НОЁН ЗУУЧ
34. Оны шилдэг даатгал МОНРЕ ДААТГАЛ
35. Оны шилдэг импортлогч БАЯСАХ ТРЕЙД
36. Оны шилдэг залуучуудын байгууллага МАНЛАЙЛЛЫН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
37. Оны шилдэг үсчин, гоо сайхны салон MATRIX
38. Оны шилдэг төсөл хөтөлбөр ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ОРОН
39. Оны шилдэг хаяг реклам, зар сурталчилгааны компани ГЭРЭЛТ ЭРИН
40. Оны шилдэг ББСБ БИД ББСБ
41. Оны шилдэг мах махан бүтээгдэхүүний үйлдвэр МАХ ИМПЭКС
42. Оны шилдэг вэб сайт БАРИЛГА.МН
43. Оны шилдэг орон нутгийн залуучуудын байгууллага УЛААНБААТАР ХОТ ДАХЬ БУЛГАН АЙМГИЙН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО
44. Оны шилдэг хэвлэх үйлдвэр “АДМОН”
45. Оны шилдэг сэтгүүл MONGOLIAN MINING JOURNAL
46. Оны шилдэг гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр СУМАН ГҮН ХХК
47. Оны шилдэг телевиз TV8
48. Оны шилдэг барилгын гүйцэтгэлийн компани “DELUXE MARSHALL VILAGE” ЦОГЦОЛБОР ХОТХОН
49. Оны шилдэг шатахуун борлуулагч компани СОД МОНГОЛ
50. Оны шилдэг интернет үйлчилгээ эрхлэгч компани ЮНИВИШИН ХХК
51. Оны шилдэг банк ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК
52. Оны шилдэг их дэлгүүр MAXMALL
53. Оны шилдэг үүрэн холбооны оператор G-MOBILE
54. Оны шилдэг төсөл хөтөлбөр ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТӨСӨЛД ХӨТӨЛБӨР
55. Оны шилдэг төсвөөр дэлгүүр ЕМАРТ СҮЛЖЭЭ ДЭЛГҮҮР
56. Оны шилдэг ургамлын тос, тосон бүтээгдэхүүн МОНМАСЛО ХХК
57. Оны шилдэг мэдээллийн технологийн компани АЙ ТҮҮЛС ХХК I TOOLS LLC
58. Оны шилдэг уул уурхайн компани МЕРА ХХК
59. Оны шилдэг зар сурталчилгааны сонин ШУУРХАЙ ЗАР
60. Оны шилдэг хотхон, хороолол ГЭГЭЭНТЭН ЦОГЦОЛБОР ХОРООЛОЛ
61. Оны шилдэг ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр ЭРДЭНЭТ ХИВС ХХК
62. Оны шилдэг барилгын материал үйлдвэрлэгч компани МОНПОЛИМЕТ ГРУПП
63. Оны шилдэг боловсрол зуучлалын байгууллага ВОРЦД КОРЕА ГРУПП
64. Оны шилдэг тавилга үйлдвэрлэгч SOHO MEBEL
65. Оны шилдэг аялал жуулчлалын компани МОНГОЛ АЯЛАЛ ХХК
66. Оны шилдэг FM Радио ШИНЭ МОНГОЛ РАДИО
67. Оны шилдэг цэцэрлэг ОДТОЙ ЖААЛУУД